



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/817

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "Б" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 20, 21 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсан Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, лабораторийн шинжилгээгээр баталгаажсан үрээр тариалалт хийж, чанартай, аюулгүй экологийн цэвэр хүнсийг зах зээлд нийлүүлнэ гэсэн заалтын дагуу энэ намар 20 тонн элит сортын төмсний үрийг тариаланчдаас худалдан авах арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойг 12 дугаар сард багтаан аймгийн хэмжээнд тэмдэглэн явуулсугай.

3. Иргэдэд олгох элит сортын төмсний үнийг 1 дүгээр хавсралтаар, үрийн төмс хадгалж байгаа зоорины ажиллах үеийн түлш, галчийн цалингийн зардлыг 2 дугаар хавсралтаар, Атрын 60 жилийн ойн арга хэмжээний зардлыг 3 хавсралтаар тус тус баталсугай.

4. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 21,800,000 төгрөг /Хорин нэгэн сая найман зуун мянган/-ийг "Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх" хөтөлбөрийн зардлаас гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газрын дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Ганданповрон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ




Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 06-ны А/817 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ТӨМСНИЙ ҮР НИЙЛҮҮЛСЭН ИРГЭД

Д/д	Сумын нэр	Багийн нэр	Овог нэр	Үрийн хэмжээ /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Буянт	Норжинхайрхан	Н.Бактияр	500	400	200000
2		Норжинхайрхан	Л.Одгариг	1000	400	400000
3		Норжинхайрхан	С.Жаханбек	1000	400	400000
4	Манхан	Төгрөг гол	Г.Буянбат	500	400	200000
5		Төгрөг гол	Б.Долгорсүрэн	500	400	200000
6	Мянгад	Баянхошуу	А.Баатархан	1000	400	400000
7		Баянхошуу	Д.Лхагвасүрэн	500	400	200000
8		Баянхошуу	Б.Досенбек	500	400	200000
9		Баянхошуу	О.Нарансүмбэр	500	400	200000
10		Баянхошуу	А.Авдал	500	400	200000
11	Ховд	Улаанбураа	Х.Хуат	500	400	200000
12		Улаанбураа	С.Асанбай	500	400	200000
13		Улаанбураа	А.Хизат	500	400	200000
14	Эрдэнэбүрэн	Хар ус	Д.Цэрэндулам	1000	400	400000
15	Жаргалант	Цамбагарав	Т.Батхуяг	2000	400	800000
16		Магсаржав	С.Пүрэв	1000	400	400000
17		Цамбагарав	Зэвсэгт хүчний 123-р анги	2000	400	800000
18		Рашаант	А.Төлөөв	1000	400	400000
19		Рашаант	К.Досан	1000	400	400000
20		Наран	А.Махмед	500	400	200000
21		Алагтолгой	Б.Энхчимэг	500	400	200000
22		Рашаант	А.Кендебай	1000	400	400000
23		Наран	К.Токтоган	1000	400	400000
24		Цамбагарав	Ч.Зоригт	1000	400	400000
				20.000	400	8.000.000



Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 06-ны А/817 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ҮРИЙН ТӨМС ХАДГАЛЖ БАЙГАА ЗООРИНЫ АЖИЛЛАХ ҮЕИЙН
ТООЦОО

д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Нүүрс	тн	5	110,000	550,000
2	Мод	м3	1	250,000	250,000
3	Цахилгаан	сар	5	350,000	1,750,000
4	Цалин	сар	5	350,000	1,750,000
	Нийт				4,300,000

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 06-ны А/817 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСАД АТАР ГАЗАР ЭЗЭМШИЖ, ГАЗАР ТАРИАЛАНГ
ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛТЭЙ БИЕ ДААСАН САЛБАР БОЛГОН
ХӨГЖҮҮЛСНИЙ ТҮҮХТ 60 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Баримтат кино	ш	1	1,000,000	1,000,000
2	Урлагын тоглолт, театрийн заалны зардал	ш	1	8,00,000	800,000
3	Анонс	ш	1	200,000	200,000
4	Хүндэтгэлийн хүлээн авалт		250	30,000	7,500,000
	Нийт				9,500,000

-оОо-